



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 6 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих
төслийн талаар авах зарим арга
хэмжээний тухай

Засгийн газрын тухай жуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл-ийг хэрэгжүүлэх ажлын
хүрээнд төслийн нэгжийн чиг үүргийг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"
терийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гэрээний үндсэн дээр
гүйцэтгүүлж, холбогдох зардлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны
батлагдсан төсвийн бэлцэн хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардлаас
санхүүжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дагдорж, Терийн өмчийн
бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т зөвшөөрсүгэй.

2. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" терийн өмчит
хязгаарлагдмал хариуцлагатай компанийг цаашид санхүүгийн хувьд бие даасан
хэвээс хараат бус байдлаар ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч
хэрэгжүүлэхийг Терийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Ц.Ням-Осор)-т
талгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ